



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шим-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/04/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 99432788 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433081, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ШИМ-УС ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Н.ГАНБАТ ТАНАА

2024.03.20 № 4/117
танай 2024.01.29-ны № 13 -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шим-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Шим-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн засаг даргын тамгын газартай болон бусад талуудтай байгуулсан гэрээний дагуу хашаандаа сайхан амьдарцаага төсөл, эко нолын гэрээт ажил, амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн гэрээт ажил зэргээс үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,301,217.50 мянган төгрөг төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шим-Ус ОНӨААТҮГ нь тайлант онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд батлуулсны дагуу 6 багцын 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан. (ТӨГРӨГӨӨР)**

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41,608,417.64	31,594,635.16
1.1.2. Дансны авлага	206,237,669.55	450,142,922.07
1.1.3. Татвар НДШ-ийн авлага		
1.1.4. Бусад авлага	7,310,000.00	30,000.00
1.1.5.Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6.Бараа материал	879,262,719.39	1,023,780,284.83
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.8. Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10		
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	1,134,418,806.58	1,505,547,842.06
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	17,734,272,783.36	26,926,093,666.42
1.2.2 Биет бус хөрөнгө	9,555,000.00	9,025,000.00
1.2.3 Биологийн хөрөнгө		
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,743,827,783.36	26,935,118,666.42
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,878,246,589.94	28,440,666,508.48
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1 Дансны өглөг	12,234,413.71	212,199,274.41
2.1.1.2 Цалингийн өглөг		
2.1.1.3 Татварын өр	38,492,550.89	7,400,000.00
2.1.1.4 НДШ-ийн өр		
2.1.1.5 Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6 Хүүний өглөг		
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8 Урьдчилж орсон орлого		
2.1.1.9 Нөөц өр төлбөр		
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	1,251,528,601	1,251,528,601
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам		
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,302,255,565.60	1,471,127,875.41
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1 Урт хугацаат зээл		
2.1.2.2 Нөөц өр төлбөр		
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5 Зээл		
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2 Өр төлбөрийн нийт дүн	1,302,255,565.6	1,471,127,875.41
2.3 Эздийн өмч		
2.3.1 Төрийн		
2.3.2 Хувийн	10,086,961,840.33	10,086,961,840.33

2.3.3 Хувьцаат		
2.3.4 Халаасны хувьцаа		
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	697,760,587.00	697,760,587.00
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	7,758,292,638.82	17,431,634,837.82
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-967,024,041.81	-1,246,818,632.08
2.3.11 Эздийн өмчийн дүн	17,575,991,024.34	26,969,538,633.07
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,878,246,589.94	28,440,666,508.48

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан. (ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	2,797,338,924.65	3,908,323,795.46
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,064,405,915.58	3,351,735,895.85
3. Нийт ашиг (алдагдал)	732,933,009.07	556,587,899.61
4. Түрээсийн орлого		
5. Хүүний орлого		
6. Ногдол ашгийн орлого		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого		
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	666,748,922.11	810,326,391.68
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал		
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-1,676,928.96
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		5,843,668.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	66,184,086.96	(249,571,753.03)
19. Орлогын татварын зардал	6,607,638.03	
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	59,576,448.93	-249,571,753.03
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	59,576,448.93	-249,571,753.03
23. Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	59,576,448.93	-249,571,753.03
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан. (ТӨГРӨГӨӨР)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	10,086,961,840	697,760,587	650,457,345	(1,022,548,234)	10,412,631,538
2	НБББ өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	7,107,835,204	(4,052,257)	7,103,782,947
3	Залруулсан үлдэгдэл					-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	59,576,449	59,576,449
1	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	10,086,961,840	697,760,587	7,758,292,639	(967,024,042)	17,575,991,024
2	НБББ өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(249,571,753)	(249,571,753)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			9,673,342,199	(30,222,837)	9,643,119,362
7	Зарласан ногдол ашиг					-
8	ДҮН-ийн хэрэгжсэн дүн					-
9	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	10,086,961,840	697,760,587	17,431,634,838	(1,246,818,632)	26,969,538,633

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан. (ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1 Мөнгөн орлогын дүн	3,171,779,083.26	4,020,807,250.68
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,969,421,836.16	4,001,688,526.27
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	202,357,247.10	19,118,724.41
1.2 Мөнгөн зарлагын дүн	3,134,320,162.38	4,030,821,033.16
Ажиллагчдад төлсөн	892,505,894.56	1,247,849,749.89
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	243,304,131.98	332,260,691.00
Бараа материал худалдан авахад төлсөн	1,066,810,501.50	1,280,078,475.00
Ашиглалтын зардал төлсөн	405,088,583.02	541,211,626.64
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	110,407,102.00	198,836,507.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	266,432,787.04	413,278,120.64
Даатгалын төлбөрт төлсөн	2,479,125.00	5,500,825.00
Бусад мөнгөн зарлага	147,292,037.28	11,805,037.99
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	37,458,920.88	(10,013,782.48)
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	32,802,000.00	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	32,802,000.00	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(32,802,000.00)	-
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн		-
Мөнгөн зарлагын дүн		-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,656,920.88	(10,013,782.48)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,981,496.76	41,608,417.64
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,638,417.64	31,594,635.16

2.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он Төлөвлөгөө	2023он Гүйцэтгэл	Зөрүү +/-
1	Нийт орлого	мян,төг	3,338,050.50	3,908,323.67	-570,273.17
2	Нийт зардал	мян,төг	3,260,140.00	4,157,895.48	-897,755.48
3	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	мян,төг	77,910.50	-249,571.81	327,482.31
4	Татвар - ААНБОО	мян,төг			0.00
5	Татварын дараах ашиг, алдагдал	мян,төг	77,910.50	-249,571.81	327,482.31
6	Тусгай зөвшөөрөл хүсэх үйл ажиллагааны - Цэвэр, бохир усаар				0.00
6.1	Орлого	мян,төг	3,338,050.50	3,908,323.67	-570,273.17
6.2	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	мян,төг	2,801,665.30	2,607,106.17	194,559.13
6.3	Бусад орлого	мян,төг	536,385.20	1,301,217.50	-764,832.30
6.4	Зардал	мян,төг	3,260,140.00	4,157,895.48	-897,755.48
6.5	Ашиг алдагдал	мян,төг		-249,571.80	249,571.80
10	Нийт ажиллагсад	тоо	127	112	15.00
10.1	Цалингийн сан	мян,төг	1,713,918.00	1,339,953.90	373,964.10
10.2	Дундаж цалин	төгрөг	1,152,346.00	996,989.5	155,356.5

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,512.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 12,512.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 12,512.6 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн арга аргачлалыг тусгаагүй, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын болон хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулан мөрдөж ажиллах.

3.1.2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн орлогын тайланд орлого, зардлыг зөв ангилж тайлагнаагүй, санхүүгийн байдлын тайланд газар эзэмших эрхийг үндсэн хөрөнгийн хэсэгт тусгасан зэрэг зөрчил илэрч байгаа нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын 2 дугаар бүлгийн 2 дугаар зүйлийн (е)-д “Газар эзэмших эрх”, 3 дугаар бүлгийн (б)-д “Орлого ба зардлыг тэдгээрийн үүсэн гарч буй шалтгаанаар нь ангилна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар журмыг мөрдөж ажиллах.

3.1.3. Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг гаргаагүй, тайлант үеийн алдагдлыг ирээдүйд шилжүүлэн бүртгэх тооцоолол хийж бүртгэлд тусгаагүй нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйл “Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох”-ыг болон Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам” журамтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг тайланг гаргаж хэвших, алдагдал шилжүүлэлтийг тооцон бүртгэж байх.

3.1.4. Цалингийн тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөдөлмөрийн хууль, ТУЗ-ийн хурлын шийдвэр, хамтын гэрээг үндэслэн ажилчдад хоолны мөнгө олгох тушаалыг дарга гарган хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ажилчдад хоолны мөнгийг олгохдоо аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийн түүний дагуу өдрийн хоолоор үйлчлүүлэн хоолны мөнгийг тухайн байгууллагад шилжүүлж байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-т “аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

түүнтэй адилтгах бусад орлого”, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1.7-д “хоол, унааны мөнгө” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдад олгосон хоолны мөнгөнөөс хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг тооцон суутгаж төсөвт төвлөрүүлж байх.

3.1.5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тус байгууллага 2023 онд Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд оруулбал зохих 157 мэдээллээс 37 мэдээллийг хугацаандаа оруулсан, 38 мэдээллийг оруулсан ч нийтэд ил тод болгоогүй, 12 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан, 70 мэдээллийг оруулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-д “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан мэдээлнэ” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Шим-Ус ОНӨҮГ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй	1						1				
	Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын баримтлан Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэн гаргаагүй	1						1				
	Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг гаргаагүй, тайлант үеийн алдагдлыг ирээдүйд шилжүүлэн бүртгэх тооцоолол хийж бүртгэлд тусгаагүй	1							1			
	Ажилчдад олгосон хоолны мөнгөнөөс нийгмийн даатгалын шимтгэл тооцож төлөөгүй	1	12,512.6						1	12,512.6		
ДҮН		4				-	-	4	12,512.6			

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Шим-Ус ОНӨҮГ	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон болон мэдээлээгүй.	1							1	
Нийт дүн		1							1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл*5.1 аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл*

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			